



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/1385

Мандалговь

Нийгмийн ажилтны ёс зүйн салбар
хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/151 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны жишиг дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, нийгмийн ажилтнуудын ёс зүйн алдаа, зөрчлийг хэлэлцэж шийдвэрлэх, нийгмийн ажлын ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх үүрэг бүхий салбар хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Ш.Эрдэнэсүвд (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: С.Нандинтуяа (Цэгцбилиг сургуулийн нийгмийн ажилтан)

Гишүүд: Т.Хэнчбиш (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа хяналтын хэлтсийн дарга)

Г.Содномдаржаа (Сайнцагаан сумын Боржигон Мандал өрхийн эмнэлгийн эрүүл мэндийн нийгмийн ажилтан)

А.Анухатан (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нийгмийн ажилтан)

2. Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны дүрмийг баталж, хэрэгжүүлэх, нийгмийн ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар хороо (Ш.Эрдэнэсүвд)-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан “Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо байгуулах тухай” 2019 оны А/398 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822111258